



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2021 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 01

Мөрөн

**Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх
таван жилийн үндсэн чиглэл батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “а”, “е”, 19 дүгээр зүйлийн 19.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.1, 9.11.1, 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус III хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг нэгдүгээр, “Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилт арга хэмжээний санхүүжилтийг жил бүрийн хөгжлийн төлөвлөгөө, төсөвт тусган үр дүнтэй хэрэгжүүлж, холбогдох хуулийн дагуу тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ш.Идэрбаясгалан)-д үүрэг болгосугай.

3. Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх хороодод даалгасугай.

ДАРГА

Г.МӨНГӨНХУЯГ

119190004